ТАТВАРЫН АЛБАНЫ 2025 ОНЫ ЁС ЗҮЙН ДЭД ХОРООНЫ
ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХЭРЭГЖИЛТИЙН
ТАЙЛАН

НЭГ. Товч танилцуулга

Улсын Их Хурлын 2024 оны 27 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр"-ийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд төрийн албан хаагчдын ёс зүйн мэдлэг, ухамсар, хариуцлагыг дээшлүүлэх, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор сургалт, соён гэгээрүүлэх, нөлөөллийн болон мэдээлэл, сурталчилгааны үйл ажиллагааг зохион байгуулсан. Эдгээр үйл ажиллагаа нь ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, шударга, ил тод, хариуцлагатай төрийн албыг төлөвшүүлэхэд чиглэгдсэн.

Мөн Төрийн албаны тухай хууль, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, Авлигын эсрэг хууль, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийг хэрэгжүүлэх татварын албаны албан хаагчдын үйл ажиллагаанд хяналт тавьж, хүнд суртал, авлига, ёс зүйн аливаа зөрчлөөс урьдчилан сэргийлэх, төрийн албан хаагчийн ёс зүйг чанд сахих хууль тогтоомжийн хүрээнд байгууллагын нийт албан хаагчдад Төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг сахиулах, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх, зөрчил гаргасан эсэхийг хянан шалгаж, дүгнэлт гаргах, төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилд дүн шинжилгээ хийх, "Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилд өртөх эрсдэлийг тооцох үнэлгээний аргачлал"-ыг Татварын ерөнхий газар, нийслэл, аймаг дүүргийн нийт 31 татварын албанд батлагдсан маягтаар эрсдэлийн үнэлгээ хийж, татварын албаны ёс зүйн дэд хороо нь 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэн ажилласан байна. Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн үр дүнгийн хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлтэд нийцүүлэн 2026 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгасан ажиллаа.

ХОЁР. Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийн талаар

2.1.Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт

Татварын ерөнхий газар, нийслэл, аймаг дүүргийн нийт 32 татварын албаны Ёс зүйн дэд хорооны 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан зорилт, арга хэмжээний хүрээнд сургалт, сурталчилгаа, нөлөөлийн аян мөн татварын албаны ажилтан, албан хаагчийн сургалт хөгжлийн 2025 оны төлөвлөгөөний дагуу Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөрийн хүрээнд дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн байна. Үүнд:

1.Татварын албаны нийт албан хаагчдын ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх ажлын хүрээнд:

- "Хүндэлье, энэрье" ёс зүйн нөлөөллийн аяны хүрээнд Төрийн албан хаагчийн эрхэмлэх 9 зүйлийн цуврал видео бичлэг, "Ёс зүйн сахилга хариуцлагын батламж" гардуулах, Ажилчдын бүтээлч сэтгэлгээ, танин мэдэхүйн шинэлэг арга, хамтын ажиллагаа, харилцааны чадвар сайжруулах чиглэлээр нөлөөлөл, соён гэгээрүүлэх ажлын хүрээнд "Канвас арт зураг зурах", "Ил захидал илгээх", "Дараагийн хүндээ юу өгөх вэ","Өнгөлөг өдөр", "Ёс зүйтэй хамт олон", "2025 оны хамгийн, хамгийн" , "Нэг өдрийн менежер" нөлөөллийн аянг зохион байгуулан сар бүр "Ёс зүйтэй албан хаагч"-ийг шалгаруулж, мөн сар бүр уриа дэвшүүлж 1-р сарыг "Тангаргийн сар" 2-р сарыг "Харилцаа хандлагыг сайжруулах сар" 3-р сарыг "Өргөдөл гомдлыг шийдвэрлэх сар", 4-р сарыг "Үүрэг даалгаврын биелэлтийн сар", 5-р сарыг "Соён гэгээрүүлэх сар" болгон ажиллаж үйлчилгээний чанарыг сайжруулах, албан хаагчдын ёс зүй, харилцаа хандлагыг дээшлүүлж, албан хаагчдыг чадавхижуулах, хяналтыг сайжруулахад үр дүнтэй байсан.

- "Төрийн албан хаагчийн ёс зүйн хэм, хэмжээ", "Төрийн албаны шинэтгэл, манлайлал", "Ёс зүй бидний амьдралд", "Харилцаа ба ёс зүй " , "Ажлын байрны ёс зүй", "Бүсчилсэн хөгжил – Төрийн албаны манлайлал" сэдэвт зөвлөгөөнд оролцож, "Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль тогтоомжийн хэрэглээ", "Төрийн албан хаагчийн ёс зүйн манлайлал", "Төрийн албаны шинэтгэл – ёс зүй"
- "Ажлын байрны стрессээс ангид байх, эерэг хандлага бий болгох, йог, бясалгалын ач тус", "Төрийн албан хаагчийн ёс зүй ба эрүүл мэнд", "Монголын татварын албаны үйлчилгээ, албан хаагчид тавих ерөнхий шаардлага, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх", "AI" (хиймэл оюун ухаан) хэрэглээ, "Ёс зүй ба хувийн орон зай", "Хөдөлмөрийн бүтээмж ба амжилтын сэтгэл зүй", "Монголын татварын албаны үйлчилгээ, ажилтан, албан хаагчид тавих ерөнхий шаардлага" стандартыг албан хаагчдад сурталчилан таниулах, уншиж судлуулах, мэдлэг чадварыг дээшлүүлэх зорилгоор албан хаагчдын дунд асуулт хариултын "QUIZ ETHICS NIGHT" тэмцээн, үгийн сүлжээ, тест бөглүүлэх, "Монгол 7 удирдахуйн сургаал", "Хамт олны эерэг уур амьсгалыг бүрдүүлэх нь", "Хувь хүний ёс зүйн харилцаа, хандлага", "Хайрцаггүй сэтгэлгээ", "Хувь хүний зан төлөв байгууллагын уур амьсгалд нөлөөлөх нь", "Төрийн албан хаагчийн ёс зүй, харилцаа хандлага, сэтгэл хөдлөлийн менежмент", "Стрессийг давах туулах нь", "Харилцааны соёлыг урлах", "Төрийн албаны шинэтгэл-Та бидний хандлагын өөрчлөлтөөс шалтгаална " , "Татварын гадна ба дотно",
- Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр 2023-2030 он "Албан тушаалтанд тавигдах хориглолт, хязгаарлалт", "Авлигын ойлголт, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх", "Авлигын гэмт хэргийн тухай", "Гэмт хэрэг гарсан шалтгаан нөхцлийг арилгах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх нь", "Авлигын гэмт хэргийн онцлог, Эрүүгийн эрх зүйн шинж",
- Шинээр татварын улсын байцаагчийн албан тушаалд томилогдсон , албан тушаал сэлгэн томилогдсон , хүүхэд асрах чөлөөнөөс ажилдаа орсон албан хаагчийг ажлын байрны дагалдуулан сургалтанд хамруулж, татварын албаны бүтэц, чиг үүрэг, албан тушаалын тодорхойлолт, ажлын үүргийн хуваарь болон ажлын байранд шаардлагатай мэдлэг, ур чадварыг олгож, байгууллагын стандарт, ёс зүй, нууцын зохицуулалт, мэдээллийн аюулгүй байдалын сургалт зохион байгуулж. Мөн төрийн албан хаагчийн манлайллыг хэрэгжүүлж, тангараа чандлан мөрдөх соёлыг хэвшүүлэх үүднээс шинээр тангараг өргөсөн албан хаагчдад хамт олны зүгээс талархал дэвшүүлж, баяр хүргэх үйл ажиллагааг зохион байгуулсан.

Татварын албаны нийт албан хаагчдын ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх 169 удаагийн сургалтад давхардсан тоогоор 4652 албан хаагч хамрагдсан /Үүнээс 1164 эрэгтэй албан хаагч, 3411 эмэгтэй албан хаагч/ байна.

2.Татварын албаны ёс зүйн дэд хорооны нийт гишүүдийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх ажлын хүрээнд:

- Төрийн албаны зөвлөлөөс зохион байгуулагддаг 7:4:10 арга зүйн сургалт
- Төрийн албаны зөвлөлөөс зохион байгуулсан Төрийн албаны ёс зүйн төлөв байдал Тандан судалгаа сэдэвт цахим сургалт
- "Ёс зүйн дэд хорооны ажиллах журам"
- МУ-ын Төрийн албаны сургууль Удирдлагын академийн "Ёс зүйн дэд хорооны гишүүдийг чадавхжуулах нь"
- "Төрийн албан дахь ёс зүйн төлөв байдлыг тандах судалгаа, зарим төрийн байгууллагд хийсэн ёс зүйн зөрчилд өртөх эрсдэлийн үнэлгээний танилцуулга"
- "Харилцаа ба ёс зүйг эрхэмлэх"
- Монгол Улсын Ёс зүйн хорооноос зохион байгуулсан Төрийн албан хаагчийн "Ёс зүйн сургагч багш бэлтгэх" хөтөлбөрт хамруулсан байна.

Татварын албаны ёс зүйн дэд хорооны нийт гишүүдийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх 38 удаагийн сургалтад давхардсан тоогоор 356 албан хаагч хамрагдсан /Үүнээс 105 эрэгтэй албан хаагч; 241 эмэгтэй албан хаагч/ байна.

Дээрх сургалтаар ёс зүйн талаарх мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, албан хаагчийн хариуцлагатай, шударга байдлыг төлөвшүүлэх зорилгоор зохион байгууллаа.

Сургалтын хүрээнд Төрийн албаны тухай хууль, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, түүнчлэн ёс зүйтэй холбоотой холбогдох журам, заавар, тэдгээрийн зорилго, хэрэгжилтийн өнөөгийн байдал, практикт тулгарч буй асуудал төрийн албан хаагчийн хүлээх ёс зүйн үүрэг, хариуцлага, хориглох үйлдэл, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх асуудлыг онцлон авч үзэж, хууль зөрчсөн тохиолдолд хүлээлгэх хариуцлагын талаарх ойлголтыг олгосон.

2.2.Томилох эрх бүхий албан тушаалтны ёс зүйн манлайлал:

Татварын ерөнхий газрын дарга нь Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1, 13.2 дахь заалтын дагуу Татварын ерөнхий газар, нийслэл, аймаг дүүргийн нийт 32 татварын албаны ёс зүйн дэд хороодын тушаалыг баталж үйл ажиллагааг нь явуулж байна.

Татварын ерөнхий газар, нийслэл, аймаг дүүргийн нийт 32 татварын албаны ёс зүйн дэд хороодод нийт 72 гомдол мэдээлэл бүртгэгдсэнээс Татварын ерөнхий газар, аймгийн томилох эрх бүхий албан тушаалтан тушаалаар 11 албан хаагчдад ёс зүйн хариуцлага ногдуулсан байна.

Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийг хэрэгжүүлсэн үйл ажиллагааны тайлан, зөрчлийн шийдвэрлэлтийг Нийслэл, аймаг дүүргийн нийт 32 татварын албад өөрсдийн цахим хуудсандаа тухай бүр байршуулсан ажиллаж байна. Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль болон Ёс зүйн хорооны 2024 оны 05 дугаар тогтоол "Ёс зүйн дэд хорооны ажиллах журам"-д заасан дэд хорооны гишүүдийн баталгааг хангах эрхийн хүрээнд урамшуулалыг хууль тогтоомжид нийцүүлэн тухай бүр олгосон 11 татварын алба, тал олгосон 6 татварын алба, огт олгоогүй 15 татварын албан байна.

2.3. Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагаа:

Татварын ерөнхий газар, нийслэл, аймаг дүүргийн нийт 32 татварын албаны хэмжээнд тайлант хугацаанд албан хаагчдтай холбоотой гомдол, мэдээлэл бичгээр 44 гомдол, цахим шуудангаар 2 гомдол , амаар 3, 11-11 төвийн харилцах утсаар ирүүлсэн 17 гомдол, дотоод хяналт шалгалтаар 5 гомдол, гэмт хэрийг шинжтэй 1 гомдол, нийт 72 гомдол хүлээн авч, тухайн бүр хуралдаж шийдвэрлэсэн байна. Төрийн албан хаагчийн ёс зүйн асуудлаар гаргасан гомдол, мэдээлэл, түүний шийдвэрлэлтийн талаарх бүртгэлийн маягтыг хавсаргав. / ЁЗХ-ны 13 дугаар тогтоолын 3 хавсралт/

Татварын албаны ёс зүйн дэд хороодод ирсэн нийт 72 гомдол, мэдээлэлийг хянан шийдвэрлэх ажиллагаа хийж 1 гэмт хэргийн шинжтэй, судлагдаж байгаа гомдол, мэдээлэл 2, ёс зүйн зөрчил гаргаагүй 51 дүгнэлт, ёс зүйн зөрчилтэй 18 дүгнэлт гаргаж томилох эрх бүхий албан тушаалтанд хүргүүлэн 2 албан хаагчдад гомдол, мэдээлэл гаргагчаас уучлалт гуйхыг үүрэг болгох, 1 албан хаагчдад олон нийтийн өмнө уучлалт гуйхыг үүрэг болгох, 2 албан хаагчдад өөрт нь ганцаарчилсан хэлбэрээр сануулах, 2 албан хаагчдад байгууллагын албан хаагчдын өмнө нээлттэй сануулах, 8 албан хаагчдад сайн дураар ёс зүйн хариуцлага хүлээгэж гомдол, мэдээлэл гаргагчаас уучлалт гуйх ёс зүйн хариуцлага ногдуулж, 3 ёс зүйн зөрчилд томилох эрх бүхий албан тушаалтан хариуцлага хүлээлгэх тушаал шийдвэр гаргаагүй байна.

Татварын ерөнхий газрын 2025.04.30-ны өдрийн 03/1201 дугаартай албан бичиг, Татварын ерөнхий газрын дэргэдэх Ёс зүйн дэд хорооны "ЗӨВЛӨМЖ"-өөр төрийн албан хаагч албан тушаалын чиг үүргээ хэрэгжүүлэх явцдаа хууль, ёс зүйн хэм хэмжээг сахин мөрдөх үүрэгтэй бөгөөд хариуцлагатай, төвч шудрага байдлыг эрхэмлэхийн зэрэгцээ байгууллагын удирдах албан тушаалтнуудын зүгээс байгууллагын соёлыг зөв төлөвшүүлэх, харилцаа хандлага, ёс суртахуун, сэтгэл зүйн таатай уур амьсгал бүрдүүлэхэд онцгой анхаарах шаардлагатай бөгөөд төрийн албан хаагчийн ёс зүйн байдал нь түүний мэргэшил, мэдлэг ур чадвараас дутуугүй ажлын үр дүнд эерэг нөлөө үзүүлэх талаар зөвлөсөн.

Монгол Улсын Ёс зүйн хорооны 2025 оны 09 дүгээр сарын 26-ны өдрийн 06 дугаар тогтоолоор батласан аргачлалын дагуу "Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилд өртөх эрсдэлийг тооцох үнэлгээний аргачлал"-ын дагуу ёс зүйн зөрчилд өртөх эрсдэлийн үнэлгээг Татварын ерөнхий газар, нийслэл, аймаг дүүргийн нийт 31 татварын албанд батлагдсан маягтаар эрсдэлийн үнэлгээ хийж, 1 татварын албан нь "үнэлгээг хийхдээ

өөрийн болон хөндлөнгийн үнэлгээний хэлбэрийг дангаар нь эсвэл хослуулан хэрэглэх" гэсний дагуу 2026 онд багтаан хийхээр төлөвлөсөн байна.

Нийгмийн сэтгэл зүйд зерэгээр нөлөөлөх, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, ёс зүйн боловсролыг дээшлүүлэх нөлөөллийн ажлыг хэрэгжүүлэх зорилгоор албан хаагчдын дунд төрийн албан хаагчийн эрхэмлэх 9 зүйлийг цувралаар видео хэлбэрээр хүргэх замаар нөлөөллийн аяныг зохион байгуулсан. / Давхардсан тоогоор 93,473 хүн үзсэн байна /

Ёс зүйн дэд хорооны бүрэлдэхүүн хөдөлгөөн бүртгэх, төрийн албан хаагчид ирүүлсэн гомдол мэдээллийг шийдвэрлэсэн байдлыг бүртгэх, ёс зүйн мэдээллийн бүртгэл хяналтын дэд систем дүгнэлт шийдвэрийг тухай бүр бүртгэн тайлагнах замаар ажиллаж байна.

Гарсан үр дүн, ололт амжилт:	Бэрхшээл:
• Ёс зүйн дэд хорооны гишүүдэд 1-11 сард урамшууллыг олгосон нь гишүүд ажиллахад нөлөөлсөн. • Байгууллагад нөлөөллийн ажил зохион байгуулснаар албан хаагчид өдөр бүрийг эерэг хандлага, эрч хүчтэй эхлүүлэхийн ач холбогдлыг ухамсарлаж, хамтын ажиллагаа, харилцан ойлголцол сайжран, ажлын уур амьсгал дулаан, ажлын идэвх нэмэгдсэн бодит эерэг үр дүн гарсан.	• Төлөвлөгөөнд тусгагдсан сургалтуудыг зохион байгуулах, Соён гэгээрүүлэх болон нөлөөллийн ажил зохион байгуулахад, хөндлөнгийн байгууллагаар болон дотооддоо ажлын хэсэг байгуулан үнэлгээ хийлгэх зэрэгт тодорхой хэмжээний төсөв хөрөнгө байхгүй Ёс зүйн дэд хорооны гишүүд өөрсдийн санхүүгээс шийдвэрлэдэг асуудал хүндрэл байна. • Ёс зүйн дэд хорооны гишүүд нь ажил үүргийн хувьд өөр чиг үүргийг хэрэгжүүлдэг. Үндсэн ажлын хажуугаар гомдол мэдээллийг шийдвэрлэх цаг хугацаа хомс, мөн ээлийн амралтаа авсан үед ирсэн гомдол мэдээллийг цаг тухай бүр нь хянаж шалгах боломжгүйгээс болж ажил хугацаа хойшлох бэрхшээл байна. • Зарим иргэд татвар төлөгчдийн сөрөг харилцаа хандлагаас болж төрийн албан хаагчид ёс зүйн зөрчилд холбогдох нөхцөл өөрсдөөс нь үл хамааран бий болж байна. • Ёс зүйн хорооны 2025 оны 06 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилд өртөх эрсдэлийг тооцох үнэлгээний аргачлал" -ын дагуу ёс зүйн зөрчилд өртөх эрсдэлийн үнэлгээний хуудсыг албан хаагч бөглөхөд ойлгомжгүй байдал үүсч, тухайн албан хаагч нөлөөлөл, магадлалыг буруу тодорхойлсноор тухайн нэгж, хэлтсийн эрсдэлийн үнэлгээ үнэн зөв гарах боломжгүй байдал үүсч байна. • Ёс зүйн дэд хорооны гишүүд хуульд заасан баталгаагаар бүрэн хангагдахгүй. Жич: Төсвийн

	хэмнэлтээс шалтгаалан Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4.1-т заасан гишүүнээр ажилласны төлөө авах урамшуулал олгогдохгүй байна.
Санал:	
• Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуульд дэд хорооны гишүүд ээлжийн амралттай үед ирсэн гомдлыг хүндэтгэн үзэх шалтгааны улмаас сунгах гэсэн зохицуулалтыг оруулах • Ёс зүйн дэд хорооны гишүүдийн идэвх, оролцоог нэмэгдүүлэх, хариуцлагатай, үр бүтээлтэй ажиллах боломжийг дэмжих зорилгоор хуульд заасны дагуу урамшууллыг тухай бүр олгуулах саналтай байна. • Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд албан хаагчдын ажлын ачааллаас үүдэлтэй стресс, "burnout" буюу ажлаас халшрах хам шинжийг оношлох, мэргэжлийн сэтгэл зүйчийн ганцаарчилсан болон багийн зөвлөгөө авах зардлыг санхүүжилтэд тусгах • Нийгэмд болон цахим орчин, хүмүүсийн төрд итгэх итгэл буурч буйтай холбоотойгоор өдөр бүр янз бүрийн зан харилцаатай иргэд, олон нийттэй харьцдаг иймд төрийн албан хаагчийн нэр хүндийг өндөрт өргөх, төрийн албан хаагчийг хамгаалах арга хэмжээ авах • Ёс зүйн зөрчлийн шалтгаан нөхцөлд хийсэн дүн шинжилгээгээр хувь хүний хандлагаас гадна ажлын орчны таагүй нөлөөлөл, сэтгэл зүйн тогтворгүй байдал ихээхэн нөлөөлж байгаа тул байгууллагын дэргэд "Сэтгэл зүйн зөвлөгөө өгөх өрөө" эсвэл гэрээт сэтгэл зүйч ажиллуулах, Төрийн албаны зөвлөл болон Ёс зүйн хорооноос төрийн байгууллагуудад зориулсан "Сэтгэл зүйчийг ажиллуулах жишиг журам", "Сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэх тесвийн норматив"-ыг баталж өгөхөд дэмжлэг үзүүлэх. • Ёс зүйн хорооны 2025 оны 06 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилд өртөх эрсдэлийг тооцох үнэлгээний аргачлал” -ын дагуу ёс зүйн зөрчилд өртөх эрсдэлийн үнэлгээний хуудсыг албан хаагч бөглөхөд нэг мөр ойлгох боломжийг бий болгох мөн удирдах, гүйцэтгэх албан хаагчдын үнэлгээний хуудсыг тус тусад нь тохируулан гаргах • Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн дагуу Ёс зүйн дэд хорооны гишүүнийг таван жилийн хугацаагаар сонгож байгаа тул хорооны гишүүдийг мэргэшүүлэх, мэдлэг олгох сургалт, арга хэмжээг тогтмол зохион байгуулах. Мэдээ судалгаа, тайлангийн маягтийг шинээр гаргах бүрд гишүүдийг арга зүйгээр хангах нэг мөр ойлгох тал дээр дэмжих, нөхцөл бололцоо байхгүй бол тайлан мэдээг нэгтгэж буй Дээд байгууллагын нарын бичиг гишүүдийг арга зүйгээр хангах ингэснээр доод шатны гишүүдийг мэдээ мэдээллээр хангах боломж бүрдэнэ. • Дэд хорооны үйл ажиллагаа, урамшууллын санхүүгийн эх үүсвэрийг шийдвэрлэх, чадавх бэхжүүлэх хүрээнд Ёс зүйн дэд хорооны гишүүдэд урамшууллыг олгох • Үндэсний хөтөлбөрийн зорилт, шалгуур үзүүлэлттэй нийцүүлэн ёс зүйн дэд хорооны гишүүдийг ёс зүй, сахилга хариуцлага, гомдол мэдээлэл хянан шийдвэрлэх чиглэлээр чадавхжуулах сургалтад тогтмол хамруулах • Нөлөөллийн зарим ажлуудыг хэрэгжүүлэх явцад тодорхой хэмжээний санхүүжилт шаардлагатай байдаг энэ бүгдийг гишүүд хувиасаа санхүүжүүлж ажиллаж байна. Иймд уг ажлуудыг төсөвт тусган санхүүжилт шийдвэрлүүлж өгөхийг хүсэж байна. • Сургагч багш бэлтгэх шаардлагатай байна. • Аймгийн юм уу бүсийн хэмжээнд төрийн албан хаагчдад ёс зүйн боловсрол олгох сургалтын багтай болгох. • Ёс зүйн дэд хороод ажлын хажуугаар гомдол мэдээлэлээ хянан шалгаад тухай бүр нь ёс зүйн зөрчилтэй дүгнэлт гаргаад томилох эрх бүхий албан тушаалтанд хүргүүлдэг. Гэтэл ёс зүйн дэд хорооны дүгнэлтийг үндэслэн шийдвэр гаргахгүй өнгөрүүлэх асуудал нэг биш удаа гарсан. Тухайн албан тушаалтаны ёс бус үйлдлээс болж хохирсон албан хаагчид болон иргэд хохирох мөн тухайн ёс зүйн дэд хорооны хийсэн ажил талаар болох асуудал үүсдэг. Иймд Ёс зүйн дэд хорооны	

дүгнэлтийг үндэслэн шийдвэр гаргаагүй Томилох эрх бүхий албан тушаалтанд ямар хариуцлага байдаг бэ? Хариуцлагын хэлбэрийг тодорхой болгох саналтай байна.

Шалгах хэсэг:

- ☑ “Ёс зүй, сахилга хариуцлагын үнэлгээний шалгуур үзүүлэлт”-ийн дагуу үнэлгээ хийсэн эсэх.
- ☑ Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн үр дүнгийн хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлтэд нийцүүлэн баталсан үйл ажиллагааны төлөвлөгөө хавсаргасан эсэх.
- ☑ Байгууллагын 2025 оны Ёс зүйн дэд хорооны хууль тогтоомжийн хэрэгжилтийн тайланг маягтын дагуу бүрэн тайлагнасан эсэх.

БАТАЛГААЖУУЛАЛТ:

Татварын ерөнхий газрын дарга албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Цогтнаран

Ёс зүйн дэд хорооны дарга Л.Мөнхтуул

Ёс зүйн дэд хорооны нарийн бичгийн дарга Д.Даваасүрэн

Огноо: 2025 оны 12 сарын 30-ны өдөр

Ёс зүйн хорооны 2024 оны 08 дугаар
сарын 09-ний өдрийн 13 дугаар
тогтоолын гуравдугаар хавсралт

Төрийн албан хаагчийн ёс зүйн асуудлаар гаргасан гомдол, мэдээлэл, түүний шийдвэрлэлтийн талаарх бүртгэлийн маягт

Улаанбаатар
Татварын алба

№	Үзүүлэлт			Тоон мэдээлэл																																Нийт
				ТЕГ	ТЦГ	НТГ	БНД	БГД	БЗД	Налайх	СБД	СХД	ЧД	ХУД	Архангай	Баян-Өлгий	Баянхонгор	Булган	Говь-Алтай	Говьсүмбэр	Дархан-Уул	Дорноговь	Дорнод	Дундговь	Завхан	Орхон	Өвөрхангай	Өмнөговь	Сүхбаатар	Сэлэнгэ	Төв	Увс	Ховд	Хөвсгөл	Хэнтий	
	Хүлээн авсан гомдол, мэдээллийн нийт тоо:			7	1	11	2	4	11	0	4	13	2	7	0	0	1	0	0	0	0	0	0	0	1	1	0	0	0	2	1	1	3	0	72
1	Үүнээс:	Гомдол, мэдээлэл гаргасан хэлбэр	Бичгээр	7	1	7		2	7			7	2	3			1										1	1				2	1		2		44
			Цахим шуудангаар				1	1																													2
			Амаар									3																									3
			1111 төвийн харилцах утсаар			3	1				4	3		4																			1	1		17
			Хэвлэл мэдээлэл, олон нийтийн сүлжээ																																		0
			Дотоодын хяналт шалгалтаар			1		1	3																												5
		Гомдол, мэдээллийг зохих байгууллага, эрх бүхий албан тушаалтанд шилжүүлсэн үндэслэл	Гэмт хэргийн шинжтэй						1																												1
			Сахилгын шинжтэй																																		0
			Зөрчлийн шинжтэй																																		0
			Бусад																																		0
	Гомдол, мэдээлэлд холбогдсон албан хаагчийн нийт тоо:			7	1	10	2	9	10	0	4	13	5	7	0	0	1	0	0	0	0	0	0	0	1	1	0	0	0	1	1	1	3	0	77
2	Үүнээс:	Хүйс	Эр		1	6		4	3		2	1	1	2																						20
			Эм	7		4	2	5	7		2	12	4	5			1									1	1				1	1	1	3		57
		Албан тушаал	Төрийн улс төрийн																																		0
			Төрийн захиргааны	7	1	10	2	9	10		4	13	5	7			1									1	1				1	1	1	3		77
			Төрийн тусгай																																		0
			Төрийн үйлчилгээний																																		0
			Төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн удирдах болон компанийн эрх бүхий албан тушаалтан																																		0
			Олон нийтийн радио, телевизийн Үндэсний зөвлөлийн дарга, гишүүн, ерөнхий захирал																																		0
			Улсын болон орон нутгийн төсвөөс санхүүжилт авч төрийн тодорхой чиг үүргийг хууль тогтоомжийн дагуу гүйцэтгэж байгаа төрийн бус байгууллагын удирдах албан тушаалтан																																		0
			Авлигын эсрэг хуулийн 4.1.9-д заасан Ирээдүйн өв сан корпорацийн эрх бүхий албан тушаалтан, хяналтын зөвлөлийн гишүүн																																		0
		Төрийн албан хаагчийн тухай хуульд заасан Албан тушаалын төрөл	Удирдах	5		2	1							1																							9
			Гүйцэтгэх	2	1	8	1	9	10		4	13	5	6			1									1	1				1	1	1	3		68
			Туслах																																		0
	Ёс зүйн зөрчилд холбогдуулан шалгасан гомдол, мэдээллийн нийт тоо:			2		1	2	2				7		1			1								1											18
		8.1.1.иргэний хүсэлтэд анхааралтай хандаж, хуульд заасан бүрэн эрхийнхээ хүрээнд хариу өгөх		1	1	1	1	1				4		1												1										11
		8.1.2.эрх бүхий байгууллагаас баталсан хувцаслалтын шаардлагыг баримтлах						1				1																									2
		8.1.3.бусдын бие эрхтний онцлогийг зохисгүй үг, үйлдлээр илэрхийлэхийг цээрлэх, хөгжлийн бэрхшээлтэй хүний өөрийгөө илэрхийлэх үйлдлийг даган дуурайхгүй байх, ёс бус үг, хэллэг хэрэглэхгүй байх		1																														1		2

3	Ёс зүйн зөрчлийн ангилал Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 8.1, 8.2 заасан зөрчлийн ангилал	8.1.4.бусдын ажил хэрэгч саналыг үл хайхрах, мушгин гуйвуулахгүй байх, худал мэдээллийг аливаа хэлбэрээр тараахгүй байх													1																										1
		8.1.5.бусдын өөрийгөө хөгжүүлэх, мэдлэг ур чадвараа дээшлүүлэх, сурч боловсрох эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хязгаарлахгүй байх																																							0
		8.1.6.албан томилолтоор гадаад улсад ажиллахдаа дипломат ёс, жаягийг чанд баримтлах, Монгол Улсын нэр хүндэд харшилсан аливаа үйлдэл гаргахгүй байх																																							0
		8.1.7.албаны нэрийг хувийн зорилгоор ашиглахгүй байх				1				2																															3
		8.2.1.төрийн албан хаагчийн хувьд хуулиар тогтоосон иргэний эрх, эрх чөлөөний хязгаарлалтыг үг, үйлдлээр эсэргүүцэх, бусдыг өдөөн турхирах																																							0
		8.2.2.удирдлагадаа байгаа төрийн жинхэнэ албан хаагчийг улс төрийн үйл ажиллагаанд татан оролцуулах, оролцох санал тавих																																							0
		8.2.3.хүний эмзэг болон хувийн мэдээллээр бусдыг гутаах																																							0
		8.2.4.албаны чиг үүрэгтэй холбоотой мэдээллийг санаатайгаар нуун дарагдуулах, удирдлагын шийдвэр гаргах үйл ажиллагаанд саад учруулах																																							0
		8.2.5.үндэсний ев уламжлал, ёс заншлыг гутаах, дороомжлох үйлдэл хийх																																							0
		8.2.6.соёлын ялгаатай хэв шинжийг харьцуулах, шүүмжлэх, ялгавартай хандах																																							0
		8.2.7.албаны чиг үүрэгтэйгээ холбоогүй хууль зөрчсөн амлалт өгөх.																																							0
		8.2.8.албан үүргээ гүйцэтгэж байхдаа болон ажлын байранд согтуурууллах ундаа хэрэглэх																																							0
4	Судлагдаж байгаа /шийдвэрлээгүй/ гомдол, мэдээлэл:																																										3
5	Шийдвэрлэсэн ёс зүйн зөрчлийн нийт тоо:		7	1	11	2	4	10		4	13	2	7			1											1	1					1	1	3						69
	Үүнээс:	Ёс зүйн зөрчил гаргаагүй:	5	1	10	1	2	10		4	6	2	6														1					1	1	1						51
		Ёс зүйн зөрчил гаргасан:	2		1	1	2				7		1			1										1							2							18
6	Ёс зүйн хариуцлага ногдуулсан, хүлээсэн тоо:		1		1	1					7		1			1										1							2							15
	Үүнээс:	Томилох эрх бүхий албан тушаалтны шийдвэрээр ёс зүйн хариуцлага ногдуулсан: Гомдол, мэдээлэл гаргагчаас уучлалт гуйхыг үүрэг болгох	1				1																																2
		Олон нийтийн өмнө уучлалт гуйхыг үүрэг болгох																																						1
		Өөрт нь ганцаарчилсан хэлбэрээр сануулах										1															1													2
		Байгууллагын албан хаагчдын өмнө нээлттэй сануулах				1																																		2
		Төрийн албаны тухай хуульд заасны дагуу төрийн албанаас халах																																						0
		Сайн дураар ёс зүйн хариуцлага хүлээсэн: Хамт олноос уучлалт гуйх																																						0
		Гомдол, мэдээлэл гаргагчаас уучлалт гуйх									7					1																								8
		Олон нийтийн өмнө уучлалт гуйх																																						0
		Ёс зүйн хэм хэмжээг зөрчсөнөөс хүлээн зөвшөөрч, өөрийн хүсэлтээрээ албан тушаалаас чөлөөлөгдөх																																						0
7	Харьяалах дээд шатны байгууллагын Дэд хороонд гаргасан гомдлын тоо:																																									0
	Үүнээс:	Судлагдаж байгаа /шийдвэрлээгүй/ гомдол, мэдээлэл:																																									0
		Дүгнэлтийг хэвээр үлдээсэн:																																									0
		Дүгнэлтийг хүчингүй болгосон:																																									0
8	Шүүхэд гаргасан гомдлын тоо:																																										0
	Үүнээс:	Шийдвэрийг хэвээр үлдээсэн:																																									0
		Шийдвэрийг хүчингүй болгосон:																																									0

Тайлан гаргасан:

Тайланг хянасан:

Ёс зүйн дэд хорооны нарийн бичгийн дарга Д.Даваасүрэн

Ёс зүйн дэд хорооны дарга Л.Мөнхтуул

Ёс зүйн хорооны 2025 оны ... дугаар
сарын ...-ний өдрийн ... дугаар тогтоолын
нэгдүгээр хавсралт

ТАТВАРЫН АЛБАНЫ ЁС ЗҮЙН ДЭД ХОРООНЫ 2025 ОНЫ
"ЁС ЗҮЙ, САХИЛГА ХАРИУЦЛАГЫН ҮНЭЛГЭЭНИЙ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ"

2025.12.30

№	Үзүүлэлт	Шалгуур үзүүлэлт		Авбал зохих оноо	ТЕГ	ТТТГ	НТГ	БНД	БГД	БЗД	Налайх	СБД	СХД	ЧД	ХУД	Архангай	Баян-Өлгий	Баянхонгор	Булган	Говь-Алтай	Говьсүмбэр	Дархан-Уул	Дорноговь	Дорнод	Дундговь	Завхан	Орхон	Өвөрхангай	Өмнөговь	Сүхбаатар	Сэлэнгэ	Төв	Увс	Ховд	Хөвсгөл	Хэнтий	Оноо[1] дундаж	Хувийн жин[2] дундаж
1	2	3		4	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14	15	16	17	18	19	20	21	22	23	24	25	26	27	28	29	30	31	32	5	6
1	Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт[3] (ҮХХ)	Үйл ажиллагааны төлөвлөгөөг шалгуур үзүүлэлттэй нийцүүлэн батлалсан эсэх[4]		1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	100
2		Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилд өртөх эрсдэлийн үнэлгээ хийсэн эсэх [5]		1	1	0	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1.0	90
3		Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс сэргийлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлсэн байдал	Ёс зүйн сургалтыг 2-оос доошгүй удаа батлагдсан агуулгын хүрээнд зохион байгуулсан эсэх [6]	0,5	0,5	0.5	0.5	0.5	0.5	0.5	0.5	0.5	0.5	0.5	0.5	0.5	0.5	0.5	0.5	0.5	0.5	0.5	0.5	0.5	0.5	0.5	0.5	0.5	0.5	0.5	0.5	0.5	0.5	0.5	0.5	0.5	0.5	0.5	50
			Соён, гэгээрүүлэх нөлөөллийн ажил зохион байгуулсан байдал[7]	0,5	0,5	0.5	0.5	0.5	0.5	0.5	0.5	0.5	0.5	0.5	0	0.5	0.5	0.5	0.5	0.5	0.5	0.5	0	0.5	0.5	0.5	0.5	0	0.5	0.25	0	0.5	0.5	0.5	0.5	0.4	40
			Ёс зүйн нөлөөллийн мэдүүлэг гаргасан байдал[8]	0,5	0,5	0.5	0.5	0.5	0.5	0.5	0.5	0.5	0.5	0.5	0.5	0.5	0.5	0.5	0.5	0.5	0.5	0.5	0.5	0.5	0.5	0.5	0.5	0.5	0.5	0.5	0.5	0.5	0.5	0.5	0.5	0.5	0.5	50
			Ёс зүйн зөрчлийн хариуцлагын бүртгэлийн маягт бөглөсөн байдал[9]	0,5	0,5	0.5	0.5	0.5	0.5	0.5	0.5	0.5	0.5	0.5	0.5	0.5	0.5	0.5	0.5	0.5	0.5	0.5	0.5	0.5	0.5	0	0.5	0.5	0.5	0.5	0.5	0.5	0.5	0.5	0.5	0.5	0.5	50
Хэсгийн оноо				4	4	3	4	4	4	4	4	4	4	4	3.5	4	4	4	4	4	4	4	4	3.5	4	4	3.5	4	4	3.5	4	3.75	3.5	4	4	4	3.9	39
4	Томилох эрх бүхий албан тушаалтны ёс зүйн манлайлал (ЕЗМ)	Ёс зүйн дэд хорооны дүгнэлтийг үндэслэн шийдвэр гаргасан эсэх [10] *(өөрсдөн дүгнэлтийн хувийн жингээр тооцох бөгөөд гомдол ирээгүй бол 1 оноо)*		1	0.4	1	1	0.9	0.9	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	0.5	1	1	1	1.0	90
5		Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийг хэрэгжүүлсэн үйл ажиллагааны тайлан, зөрчлийн шийдвэрлэлтийг цахим хуудсанд байршуулсан байдал[11]		1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	100
6		Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагаа, гишүүдийг урамшуулах санхүүгийн эх үүсвэрийг шийдвэрлэсэн байдал[12]		1	1	1	1	0.5	1	0.5	0	1	0.8	0.5	1	0	0	0	0	0	1	0	1	1	0	0	0	0	1	0.5	0	0	0.5	0	0	1	0.4	40
Хэсгийн оноо				3	2.4	3	3	2.4	2.9	2.5	2	3	2.8	2.5	3	2	2	2	2	2	3	2	3	3	2	2	2	2	3	2.5	2	2	2	2	2	3	2.4	24
7	Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагаа (ЁЗДХ)	Дэд хорооны бүрэлдэхүүн хөдөлгөөнийг бүртгэсэн байдал[13]		1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	0.8	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	10
8		Төрийн албан хаагчаас ирүүлсэн гомдол, мэдээллийг шийдвэрлэсэн байдал [14] *(Гомдол ирээгүй бол 1 оноо авна, нийт ирүүлсэн өргөдөл, гомдлын хувийн жингээр тооцно)*		1	0.7	1	1	0.9	0.95	1	1	1	1	1	0.15	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	0.5	0.8	1	1	1	0.9	90
9		Ёс зүйн зөрчлийн бүртгэл, хяналтын дэд систем дэх дүгнэлт, шийдвэрийг бүртгэж, тайлагнасан байдал [15]		1	1	1	1	1	1	0.8	1	0.5	1	1	1	1	1	1	1	1	0.8	1	1	1	1	1	1	1	1	1	1	0.5	1	1	1	1	1.0	90
Хэсгийн оноо				3	2.7	3	3	2.9	2.95	2.8	3	2.5	3	3	2.2	3	3	3	3	3	2.6	3	3	3	3	3	3	3	3	3	3	2	2.8	3	3	3	2.9	29
Үнэлгээний нийт оноо, хувь				10	9.1	9	10	9.3	9.9	9.3	9	9.5	9.8	9.5	8.7	9	9	9	9	9	9.6	9	9.5	10	9	8.5	9	9	9.5	9.5	8.8	7.5	8.8	9	9	10	9.2	92

Тайлан гаргасан:
Ёс зүйн дэд хорооны нарийн бичгийн дарга Д.Даваасүрэн

Тайланг хянасан:
Ёс зүйн дэд хорооны дарга Л.Мөнхтуул

-oOo-